

## ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

**Санхүүжүүлэгч:** Тэрбум Мод Сан

**Төслийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:** 2024 оны 12-р сарын 16-ны өдрийн 17:00 цаг хүртэл

**Нэг төсөлд олгох санхүүжилтийн дээд хэмжээ:** Төслийн чиглэлээс хамааран 100'000'000 төгрөг хүртэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилготойгоор 2021 оноос эхлэн орон даяар хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Энэ хүрээнд Монголбанк, Монголын Банкны Холбооны гишүүн байгууллагуудын санаачилгаар Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан (“цаашид Тэрбум мод сан гэх”)-г 2022 оны 3-р сард үүсгэн байгуулсан. Сангийн үндсэн чиглэл болох байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, мод тарих, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх нийгмийн шинж чанартай бичил төсөл хөтөлбөрүүдэд буцалтгүй тусламж болон хамтарсан санхүүжилт олгох зорилгын хүрээнд Сангийн 2024-2025 оны “Төсөл сонгон шалгаруулах хөтөлбөр”-ийн удирдамжийг нээлттэй зарлаж байна.

### 1. САНГИЙН ТУХАЙ

Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал хүн төрөлхтний хувьд нийтлэг сорилт болж, улс үндэстний аюулгүй байдал, тогтвортой хөгжилд нөлөөлөхүйц сөрөг үр дагаврыг дагуулж байна. Дэлхийн улс орнууд хамтын хүчин чармайлт гарган, тулгарч байгаа эрсдэлийг бууруулахаар нэгдэн зорьж 2015 онд Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах Парисын хэлэлцээрийг баталсан. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 76-р чуулганаар “Тэрбумаар тоологдох мод ургуулах” санаачилгыг дэвшүүлсэн. Энэхүү санаачилга нь цөлжилт, газрын доройтол, ой мод, ойн сан, усны эх үүсвэр, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах төдийгүй уур амьсгалын нөлөөллийг бууруулж, эх дэлхийнхээ өмнө хүлээж буй маш том үүрэг хариуцлага болсон.

Монгол Улсын Засгийн газар “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.2.4. “Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ”, 6.2.8. “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ”; Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.2-т “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, цөлжилт, газрын доройтлыг бууруулах үндэсний зорилтыг хэрэгжүүлэх” тухай зорилтуудыг тусган хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхийн тулд хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэхээс гадна, газар

бэлчээрийг нөхөн сэргээх, ойжуулах, мод тарих ажлыг хэрэгжүүлэх нь нүүрсхүчлийн хийг шингээх, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хамгийн үр дүнтэй шийдлүүдийн нэг юм.

2020 оны судалгаагаар манай орны нийт нутаг дэвсгэрийн 76.9% буюу 120.3 сая га талбай бүхий газар нутаг цөлжилт, газрын доройтолд өртсөн болохыг тогтоогоод байна. Үүний 25% буюу 30 орчим сая га талбай цөлжилтийн хүчтэй ба нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна. Цөлжилт, газрын доройтлын үндсэн шалтгааны 51% нь уур амьсгалын өөрчлөлт буюу байгалийн хүчин зүйл, 49% нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж судлаачид тогтоожээ.

Монгол орны ой нь мөнх цэвдэг, ус, чийгийг тогтоон барих, гадаргын усны горимыг зохицуулах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, ургамал, амьтны амьдрах таатай орчныг бүрдүүлэх зэрэг байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах хамгаалалтын өндөр ач холбогдол бүхий эмзэг тогтоцтой онцлог экосистем юм. 2020 оны байдлаар ойн сан бүхий газар 18321 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.7 хувийг, ойгоор бүрхэгдсэн талбай 7.9 хувийг эзэлж байна. 2010 онд ойгоор бүрхэгдсэн талбай нийт газар нутгийн 8.5 хувийг эзэлж байсан бол өнгөрсөн 10 жилийн хугацаанд 908 мян.га -аар багасаж, ойрхог чанар 7.9 хувь болж 0.6 хувиар буурсан нь ойн түймэр, хөнөөлт шавжийн олшрол, хууль бус мод бэлтгэлтэй холбоотой юм.

Иймд Тэрбум Мод Сангаас нийслэлийн төрийн өмчит, сургууль цэцэрлэг, эмнэлгийн орчинд ногоон байгууламж бий болгох, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн төслүүдийг санхүүжүүлэх замаар Парисын хэлэлцээрийн амлалтыг биелүүлэхэд Монгол Улсын Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр (ҮТХН)-ийн зорилт, ногоон, тогтвортой эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахыг зорьж байна.

## 2. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Сангийн 2025 оны Төсөл сонгон шалгаруулах хөтөлбөрийн хүрээнд дараах чиглэлийн төслүүдэд санхүүжилт олгоно:

✓ **Чиглэл 1 – Төрийн өмчит цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг асрамжийн газрын ногоон байгууламжийн төсөл:**

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, асрамжийн газрын гадна орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх; сургалтын зорилгоор жимсний мод, хүнсний ногоо тариалах; хүүхэд залуучуудын сурч боловсрох орчинг эрүүл болгох; багш, сурган хүмүүжүүлэгч, оюутан сурагч, эцэг эхчүүдийн дунд мод тарих, арчилж хамгаалах аргачлал, ач холбогдлын талаар мэдлэг ойлголт нэмэгдүүлэх; цаашид үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх боломжтой загварыг бий болгох төсөл хөтөлбөр багтана.

✓ **Чиглэл 2 – Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төсөл:**

Ойн хомсдол доройтлыг бууруулах, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор түймэр, хөнөөлт шавж, хууль бус мод бэлтгэлийн улмаас доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, байгалийн сэргээн

ургалтанд туслах, мод тарих, цэцэрлэгжүүлэлттэй холбоотой төсөл хөтөлбөр багтана.

### 3. ТӨСӨЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Сангаас санхүүжилт олгох төслүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

- ✓ Төсөл нь дээрх гурван чиглэлийн аль нэгтэй нийцсэн байх;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү удирдамжийн 4-т заасан зорилтот бүлэгт хамаарч байх;
- ✓ Төсөл хэрэгжүүлэх газар, талбайтай холбоотой ямар нэгэн зөрчилгүй байх. Төсөл хэрэгжүүлэх газар, талбайтай холбоотой зохих зөвшөөрөл болон бусад холбогдох арга хэмжээг авч, баталгаажуулсан байх, дахин төлөвлөлтөд ороогүй байх;
- ✓ Төсөл хэрэгжих талбай нь ойжуулалт хийх, мод тарих нөхцөл, орчин бүрдсэн байх (ус, цэвдэг, цэвэр усны нөөц, тусгай хамгаалалттай газар зэрэг экологийн өндөр ач холбогдолтой бүсүүдэд төсөл хэрэгжүүлэх бол шаардлагатай бүх зөвшөөрлүүдийг авсан байх);
- ✓ Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц болон бусад нөөцийг бүрдүүлсэн байх;
- ✓ Өмнө нь ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн гурваас дээш жилийн бодит туршлагатай байх (Чиглэл 1-т хамаарахгүй);
- ✓ Төсөл хэрэгжих хугацаанд хэмжиж болохуйц бодит үр дүн гаргах боломжтой байх;
- ✓ Төсөл хэрэгжүүлэх явцад Сангийн хяналт тайлагналт, мэдээллийн шаардлагуудыг мөрдөж ажиллах, бусад төсөл хэрэгжүүлэгчид, олон нийтэд төслийн талаар туршлага, мэдлэгийг хуваалцахад нээлттэй байх;
- ✓ Төсөл хэрэгжих гэрээт хугацаа дууссанаас хойш цаашдын арчилгаа, үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх боломж, нөөцтэй байх;
- ✓ Өргөдлийн маягт, хавсралтыг бүрэн гүйцэт бүрдүүлж, гарын үсгээр баталгаажуулсан байх
- ✓ Төслийг хэрэгжүүлэхэд хамтын санхүүжилт гаргах боломжтой бол давуу тал болно.
- ✓ Төслийн үр дүнд шинэ ажлын байр, эдийн засгийн үр өгөөж үүсэх бол давуу тал болно.

**Сан зөвхөн дээрх шалгуурыг хангасан төслүүдийг үнэлгээний шатанд оруулах тул эдгээр шалгуурыг хангаж буй эсэхийг сайтар нягтална уу.**

### 4. ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Чиглэл тус бүрт өргөдөл гаргах боломжтой байгууллагуудыг доорх хүснэгтэнд дэлгэрэнгүй харуулав.

*Жич: Хувь хүн, ашгийн төлөө болон худалдаа арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагууд хөтөлбөрт хамрагдах боломжгүй боловч доорх байгууллагуудтай хамтарсан төслийн санал ирүүлэх боломжтой.*

Өргөдөл гаргагч нь тухайн байгууллагаас нэгээс дээш хөтөлбөрийн санал ирүүлж болно. Төслийг хоёр ба түүнээс дээш байгууллага хамтран боловсруулж, өргөдөл гаргах боломжтой.

Хөтөлбөрийн үндсэн чиглэл		Өргөдөл гаргах боломжит байгууллагууд
1	Төрийн өмчит цэцэрлэг болон Ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, асрамжийн газрын ногоон байгууламжийн төсөл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, асрамжийн газрын ногоон
2	Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төсөл	Иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн байгууллага, ойн нөхөрлөл, сумын болон сум дундын ойн анги

## 5. ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

Сангаас төслийн чиглэлээс хамааран санхүүжилтийг олгоно.

Хөтөлбөрийн үндсэн чиглэл	Санхүүжилтийн хэмжээ	Хамтын санхүүжилтийн шаардлага
1 Төрийн өмчит цэцэрлэг болон Ерөнхий боловсролын сургуулийн ногоон байгууламжийн төсөл	30 сая төгрөг хүртэл	хамтын санхүүжилттэй бол давуу тал болно <i>Жич: санхүүжилтийг шууд олгохгүй бөгөөд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгэх ажлын хөлсийг Сангаас шилжүүлнэ.</i>
2 Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төсөл	100 сая төгрөг хүртэл	хамтын санхүүжилт хамгийн багадаа 20% байна

Сангийн санхүүжилтээр дараах төрлийн үйл ажиллагаа, зардлыг санхүүжүүлэхгүй:

- Шинээр хашаа худалдаж авах (уулын ойжуулалтад унанги мод ашиглан хашаажуулах зардлыг зөвшөөрнө);
- Шинээр худаг гаргах;
- Төслийн үйл ажиллагаанд хамааралгүй захиргаа, үйл ажиллагааны зардал;
- Үндсэн ажилчдын цалин;
- Цахилгаан, дулаан, усны төлбөр, байрны түрээс, харилцаа холбооны зардал;
- Барилга, байгууламж барих зардал;

- Төслийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй тоног төхөөрөмж, эд хөрөнгө худалдан авалт;
- Олон улсын аяллын зардал;
- Нам улс төрийн зорилготой аливаа үйл ажиллагааны зардал;
- Шашны шинж чанартай үйл ажиллагааны зардал;

Төслийн санхүүжилтийг шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн баримтад үндэслэн холбогдох хуваарийн дагуу олгоно.

## 6. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

- **Төсөл хэрэгжиж эхлэх хугацаа:** 2025 оны II улирал
- **Төсөл үргэлжлэх боломжит хугацаа:** 36 сар хүртэл
- **Төслийн дараа:** Төсөл хэрэгжиж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд арчилгаа, үйл ажиллагааны тогтвортой байдлын талаар явцын тайлан ирүүлнэ.

## 7. ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ

Өргөдөл бүрийг шалгаж, доорх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийнэ. Шалгуур үзүүлэлтүүд нь өөр хоорондоо уялдаатай бөгөөд тухайн өргөдлийн чанарт үнэлэлт, дүгнэлт хийхэд тэдгээрийг бүхэлд нь авч үзнэ. Төслийн чиглэлээс хамааран зарим шалгуур үзүүлэлт үнэлгээнд хамаарахгүй байж болно.

- **Төслийн үндэслэл, зорилго, үр дүн, хамрах хүрээ:** Төслийн үндэслэл, зорилго, төслөөс гарах үр дүн, нөлөөлөл, шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан боловсруулж, оновчтой тодорхойлсон байх;
- **Төслийн байршил, аргачлал:** Төсөл хэрэгжүүлэх байршил, авч хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох судалгаа, үнэлгээний дагуу оновчтой тодорхойлсон байх;
- **Төслийн бүтэц зохион байгуулалт:** Төслийн удирдлагыг үр дүнтэйгээр зохион байгуулж, нөөцийн хуваарилалтыг оновчтой төлөвлөсөн байх.
- **Төсөл хэрэгжүүлэгчийн туршлага:** Өмнө нь ижил төстэй төсөл хэрэгжүүлж байсан туршлага, сайн түүх, байгууллагын чадавхтай байх;
- **Хамтын ажиллагаа:** Төслийн хүрээнд зорилтот бүлгүүдтэй хэрхэн уялдаж ажиллах, тэдгээрийн оролцоог хангах талаар тодорхой мэдээллийг тусгасан байх, зорилтот бүлгийг төслийн чиглэл тус бүрээр тодорхойлсон байх;
- **Төслийн тогтвортой, шинэлэг байдал:** Төслийг хэрэгжүүлэх үед олон улсын сайн туршлага, тогтвортой ойн менежмент, инновацид суурилсан болон бусад дэвшилтэт техник, технологийг ашиглаж, улмаар шинэлэг, цаашид сайн жишиг болгон өргөжүүлэх боломжтой шийдлийг санал болгосон байх.
- **Хяналт, тайлагналын төлөвлөгөө:** Төслийн хэрэгжилтийн явцыг хянахад шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг бодитой тодорхойлж, хяналт, тайлагналыг хэрхэн оновчтой хийх талаар тусгасан байх;

- **Төслийн арчилгаа, тогтвортой үргэлжлэх боломж:** Төсөл хэрэгжиж дууссаны дараа ч хөтөлбөрийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэн эерэг нөлөөлөл бий болж байх. Төслийн үр дүнд бий болсон ногоон байгууламж, ой мод, зэргийг цаашид тогтвортой арчлан хамгаалж авч явах боломжтой байх;
- **Төсвийн үндэслэл, тооцоо:** Төсөлд зарцуулагдах төсвийн тооцоолол бодит, зах зээлийн үнэд суурилсан байх ёстой ба үр ашигтай, хэмнэлттэй, үр дүнтэй байх зарчмыг баримтална. Өргөдлүүдийг үнэлэхдээ төсөв, нийт тарих модны тоо, нас, төрөл, талбайн хэмжээ, үр дүн зэргийг харгалзаж, харьцуулалт хийнэ. Зардлыг хуваалцах санал дэвшүүлсэн байгууллагууд давуу талтай болно;

## 8. ӨРГӨДЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЕ ШАТ

Сангийн үйл ажиллагаа, бусад хүчин зүйлсээс хамааран доорх төлөвлөгөөт хугацаанд өөрчлөлт гарах боломжтой.

Сонгон шалгаруулалтад тэнцээгүй төслүүдэд Сангийн зүгээс албан ёсны мэдэгдэл хүргүүлэх ба сонгон шалгаруулалтын үнэлгээ, нэгдсэн дүн болон бусад тайлбар мэдээлэл өгөх үүрэг хүлээхгүй. Тухайн жилд шалгараагүй өргөдөл гаргагч нь дараа жилийн хөтөлбөрт төслийн саналыг сайжруулан ирүүлэх боломжтой.

Төслийн сонгон шалгаруулалтыг явуулахдаа Сан нь дотоод засаглал, бодлого журмуудыг мөрдөж ажиллах бөгөөд төслийн сонгон шалгаруулалтад ямар нэгэн улс төрийн нөлөө болон ашиг сонирхлын зөрчилгүй байх зарчмыг баримтална. Сангийн бодлого, журам, хандивлагчид, Удирдах зөвлөл, хороодын бүрэлдэхүүнийг [www.billiontree.mn](http://www.billiontree.mn) вебсайтаас харах боломжтой.

Огноо	Үе шат	Тайлбар
2024.10.10	Төсөл сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлах	Төсөл сонгон шалгаруулах удирдамжийн зарыг Сангийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээнэ.
2024.10-р сард	Цахим мэдээлэл өгөх	Тэрбум мод сангийн талаар болон төслийн санал ирүүлэхтэй холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгөх 2 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулна.
2024.12.16-нд	Төслийн санал, өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа	Төслийн саналыг ирүүлэхдээ цахим маягт болон холбогдох хавсралтуудын дагуу бүрэн гүйцэт мэдээлэл ирүүлнэ. Хугацаа хэтэрсэн болон дутуу бэлтгэсэн төслийн саналыг хүлээн авахгүй.
2024.12-р сард	Ажлын албаны урьдчилсан үнэлгээ болон төслийн	Ажлын алба эхний шатанд төслийн материал шаардлагын дагуу, цаг хугацаандаа, бүрэн бүтэн ирсэн эсэхийг нягталж, шаардлага

	саналын техникийн үнэлгээ	хангасан төслүүдийг Техникийн хорооны үнэлгээний шатанд шилжүүлнэ.
2025.01-р сард	Газар дээрх шалгалт болон ярилцлага	Техникийн хорооноос хамгийн өндөр үнэлгээ авсан төслийн хэрэгжих байршил дээр Техникийн хорооны төлөөлөл болон ажлын албанаас биечлэн танилцаж, төсөл хэрэгжүүлэгчтэй ярилцлага хийнэ.
2025.03-р сард	Санхүүжилт олгох төслүүдийг сонгох, батлах	Төслийн сүүлийн шатанд шалгарсан төслүүдийг Сангийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн эцэслэж батална. Шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөлөөс төслийг нэмэлт нөхцөлтэйгөөр баталж болно.
2025.03-р сард	Санхүүжилтийн гэрээ байгуулах, нөхцөл тохирох	Шалгарсан төслүүдэд мэдээлэл хүргүүлж, төсөл хэрэгжүүлэх, санхүүжилт олгох гэрээг байгуулна. Удирдах зөвлөлөөс төсөлтэй холбоотой нэмэлт нөхцөл, шаардлагыг баталсан тохиолдолд эдгээр нөхцөл дээр тохиролцож, гэрээнд тусгана.
2025.04-р сард	Шалгарсан төслүүдийг олон нийтэд зарлах	Шалгарсан төслүүдийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод зарлана.

## 9. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ, ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

### Төслийн төлөвлөгөөний зурган мэдээлэл:

- Чиглэл 1 -ийн хүрээнд хэрэгжих төслүүдийн ландшафт зураг, хэрэгжүүлэх төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хянуулж, шаардлагатай бол сайжруулалт хийнэ.
- Чиглэл 2-т хамаарах төслүүд өргөдөл илгээхдээ ажлын төлөвлөгөөний зурган мэдээллийг заавал ирүүлсэн байна.

### Хяналт:

- Сангаас төслийн хөндлөнгийн хяналт шалгалтыг зурган төлөвлөгөөний дагуу улиралд тутамд хийж, төслийн явц, модны ургалтыг хэмжинэ.
- Төслийн хүрээнд тарьсан модыг QR кодоор бүртгэлжүүлж, Сангийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэнэ. Мөн улирал тутамд төслийн бүхий л үе шатанд зураг, видео баримтжуулалтыг хийнэ.
- Шаардлагатай тохиолдолд Geospatial Tracking хэрэгслүүдийг ашиглан төслийн явцыг хянана.

### Тайлан:

- Төсөл хэрэгжүүлэгч нь төсөл хэрэгжих хугацаанд жилд хоёр удаа үйл ажиллагааны хэрэгжилтийг тусгайлан бэлтгэсэн маягтын дагуу тайлагнана.
- Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн санхүүгийн тайлан, баримтыг мөн жилд хоёр удаа бэлтгэсэн маягтын дагуу илгээнэ.

#### **Мэдээлэл, туршлага хуваалцах:**

- Төсөлтэй холбоотой бүхий л гадагшаа чиглэсэн мэдээлэл, контент дээр Сангийн логог байршуулж, Сангийн маркетингийн гарын авлагын дагуу мэдээллийн ажлыг зохион байгуулна.
- Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн хэрэгжилтийн талаар мэдээ, мэдээллийг тайланд болон олон нийтэд таниулах зорилгоор хуваалцахад нээлттэй байна.
- Төсөл хэрэгжүүлэгч нь мэдээлэл солилцох цахим группт нэгдэн өөрсдийн туршлагыг хуваалцаж, Сангаас зохион байгуулах уулзалт, арга хэмжээнд идэвхтэй оролцоно.

### **10. ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ ТУХАЙ**

- Төслийн материалыг [www.billiontree.mn](http://www.billiontree.mn) хаягаар бүртгэл үүсгэн ирүүлнэ.
- Төслийн саналыг чиглэл бүрт тусгайлан боловсруулсан өргөдлийн маягтын дагуу **2024 оны 12-р сарын 16-ны өдрийн 17:00 цагаас өмнө** ирүүлнэ үү.

### **11. ХОЛБОО БАРИХ ХАЯГ, ЛАВЛАХ УТАС**

Хэрэв танд төсөл сонгон шалгаруулах үйл явцтай холбоотой асуулт, тодруулга, зөвлөгөө авах шаардлага гарвал доорх хаягаар холбогдоно уу.

#### **“ТЭРБУМ МОД САН”**

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
1-р хороо, Парк Плэйс 904 тоот

Утас: 7775 – 2002

Цахим шуудан: [info@billiontree.mn](mailto:info@billiontree.mn)

Цахим хуудас: [www.billiontree.mn](http://www.billiontree.mn)



#### **Төслийн санал ирүүлэх маягт:**

**Чиглэл 1 - Төрийн өмчит цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, асрамжийн газрын ногоон байгууламжийн төслүүд**



**Санхүүжүүлэгч:** Тэрбум мод сан

**Төслийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:** 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 17:00 цаг хүртэл

**Нэг төсөлд олгох дээд хэмжээ:** 30'000'000 сая төгрөг хүртэл

Төслийн хэрэгжиж эхлэх хугацаа: 2025 оны II улирал

**Төсөл хэрэгжүүлэх байршил:** Улаанбаатар хот

### **Төслийн ерөнхий агуулга, зорилго**

Энэхүү төслийн хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, асрамжийн газрын гадна орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх; сургалтын зорилгоор жимсний мод, хүнсний ногоо тариалах; хүүхэд залуучуудын сурч боловсрох орчинг эрүүл болгох; багш, сурган хүмүүжүүлэгч, оюутан сурагч, эцэг эхчүүдийн дунд мод тарих, арчилж хамгаалах аргачлал, ач холбогдлын талаар мэдлэг ойлголт нэмэгдүүлэх; цаашид үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх боломжтой загварыг бий болгох төсөл хөтөлбөр багтана.

### **Төслийн хамрах хүрээ**

Энэхүү чиглэлд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, асрамжийн газрууд өргөдөл гаргах боломжтой.

Хувь хүн, ашгийн төлөө болон худалдаа арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагууд хөтөлбөрт хамрагдах боломжгүй боловч дээрх байгууллагуудтай хамтарсан төслийн санал ирүүлэх боломжтой. Төслийг хоёр ба түүнээс дээш байгууллага хамтран боловсруулж, өргөдөл гаргах боломжтой.

Уг чиглэлийн хүрээнд **нэг төсөлд 30 сая төгрөг хүртэлх санхүүжилтийг хуваарилах боломжтой боловч санхүүжилтийг төсөл хэрэгжүүлэгчид шууд олгохгүй бөгөөд мэргэжлийн байгууллагаар төслийг гүйцэтгүүлж ажлын хөлсийг Сангаас шилжүүлнэ.**

Төслийн санал ирүүлэхийн өмнө “Төсөл сонгон шалгаруулах тухай удирдамж”-тай сайтар танилцсаны дараагаар дараах маягтыг бөглөнө үү. Төслийн маягтыг бөглөхдөө асуултанд бүрэн гүйцэт, ойлгомжтой хариулсан эсэх, материалаа гүйцэт ирүүлсэн зэргийг сайтар нягталж ирүүлнэ үү. Төслийн материал ирүүлэхтэй холбоотой асуух зүйл байвал [info@billiontree.mn](mailto:info@billiontree.mn) хаягаар ирүүлэх боломжтой.

Бүрэн гүйцэт бөглөсөн өргөдлийг холбогдох хавсралтын хамт **2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 17:00 цагаас** өмнө [info@billiontree.mn](mailto:info@billiontree.mn) хаягаар илгээнэ үү.

### **Өргөдлийг явуулахдаа**

- Хариулт бүрийг заасан үгийн тоо, нүүрний хязгаарлалтад багтааж, нийт төслийн санал, өргөдлийг **15 хуудаст** багтаана уу. Үүнд хавсралтууд хамаарахгүй.
- Өргөдлийг хавсралтын хамт бүрэн гүйцэт бөглөнө үү. **Дутуу бөглөсөн өргөдлийг хүлээн авахгүйг** анхаарна уу.
- Өргөдлийг **pdf хэлбэрээр** бэлтгэж, файлын “2025 C1 – *Байгууллагын нэр*” загвараар хадгална уу.

## **А. Төслийн ерөнхий мэдээлэл**

### **А.1 Төслийн ерөнхий мэдээлэл**

<b>A.1.1 Төслийн нэр</b>			
<b>A.1.2 Төслийн хамаарах чиглэл (сонгох)</b>	Чиглэл 1 – Төрийн өмчит цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн ногоон байгууламжийн төсөл		
<b>A.1.3 Төслийн төрөл</b>	<input type="checkbox"/> Цэцэрлэг <input type="checkbox"/> Ерөнхий боловсролын сургууль <input type="checkbox"/> Бусад		
<b>A.1.4 Төслийн байршил, албан ёсны хаяг</b>			
<b>A.1.5 Төслийн хэрэгжих хугацаа</b>	<b>Эхлэх он/сар/өдөр</b>	<b>Дуусах он/сар/өдөр</b>	<b>Нийт төслийн хугацаа (сараар)</b>
<b>A.1.6 Төслийн товч танилцуулга (100 үгэнд багтаах)</b>			

### A.2 Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл

<b>A.2.1 Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын нэр</b>		<b>A.2.2 Байгуулагдсан огноо</b>	
<b>A.2.3 Регистрийн дугаар</b>		<b>A.2.4 Үйл ажиллагааны чиглэл</b>	
<b>A.2.5 Ажилтны тоо (бүтэн цагийн)</b>	Эрэгтэй: Эмэгтэй:	<b>A.2.6 Сурагчдын тоо</b>	Эрэгтэй: Эмэгтэй:
<b>A.2.7 Байгууллагын танилцуулга</b>			
<b>A.2.8 Байгууллагын бусад мэдээлэл</b>	Цахим шуудан: Утасны дугаар: Албан ёсны хаяг: Цахим хуудас: Сошиал хаягууд:		
<b>A.2.9 Удирдлагын мэдээлэл</b>	Овог нэр: Албан тушаал: Цахим шуудан: Утасны дугаар:		
<b>A.2.10 Хариуцсан ажилтны мэдээлэл</b>	Овог нэр: Албан тушаал: Цахим шуудан: Утасны дугаар:		

### A.3 Хамтран хэрэгжүүлэгч, дэмжигч байгууллагын талаар мэдээлэл (байгаа тохиолдолд)

<b>A.3.1 Хамтран хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл</b>	<b>Байгууллагын нэр</b>	<b>Байгууллагын төрөл</b>	<b>Хариуцсан ажилтны нэр, албан тушаал</b>	<b>Холбоо барих имэйл хаяг, утасны</b>
<b>A.3.2 Холбогдох, дэмжигч байгууллагын мэдээлэл</b>	<b>Байгууллагын нэр</b>	<b>Байгууллагын төрөл</b>	<b>Хариуцсан ажилтны нэр, албан тушаал</b>	<b>Холбоо барих имэйл хаяг, утасны</b>

## V. Төслийн дэлгэрэнгүй мэдээлэл

**V.1 Төслийн одоогийн нөхцөл байдал.** Төслийн нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үндэслэлийг тайлбарлах. Төслийг өөр бусад санхүүгийн механизм (төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хандив гэх мэт)-ээр яагаад санхүүжүүлэх боломжгүй талаар тодруулах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

--

**В.2 Төслийн зорилго, үр дүн.** Төслийн ерөнхий зорилго, хүрэх үр дүн, тэдгээр нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөний стратеги, Сангийн зорилго, болон бусад үндэсний болон олон улсын холбогдох бодлого, зорилтуудтай хэрхэн нийцэж буйг тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**В.3 Төслийн аргачлал.** Төслийн хүрээнд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээг тайлбарлах. Үүнд газар/хөрс бэлтгэх, мод тарих, арчлах, хянах, бүхий л үйл ажиллагаанд сурагч, багш ажилтнууд, эцэг эхийн оролцоог хэрхэн хангахтай холбоотой ажлыг багтаах. Мөн мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн ландшафтын зураг хийлгэсэн бол хавсаргах, байхгүй тохиолдолд хүсч буй ногоон байгууламжийн талаарх мэдээллийг зураг, эсвэл үгээр тайлбарлаж, илэрхийлэх (мод, үр, тарьцын төрөл, нас, тоо, тарилтын схем, арга, хашаа, хайс, тохижилт зэрэг хамгаалалт хийх шаардлага байгаа эсэх талаар тайлбарлах (1 нүүрнээс илүүгүй).

--

**Төслийн төлөвлөгөө.** Төслийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын календарчилсан төлөвлөгөөг оруулах.

Но.	Арга хэмжээний төрөл	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний тайлбар	Үр дүн	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
<b>Үйл ажиллагаа 1:</b>					
<b>Үйл ажиллагаа 2:</b>					
<b>Үйл ажиллагаа 3:</b>					
<b>Үйл ажиллагаа 4:</b>					
<b>Үйл ажиллагаа 5:</b>					
Нэмэлт тайлбар:					

**В.4 Төслийн байршил.** Төсөл хэрэгжих байршлын талаарх мэдээллийг оруулна уу (1 нүүрнээс илүүгүй).

<b>В.4.1 Төсөл хэрэгжүүлэх байршлын одоогийн нөхцөл байдлыг харуулсан фото зураг</b>	<i>Зураг оруулах эсвэл хавсаргах</i>
<b>В.4.2 Google map линк</b>	<i>Линк оруулах...</i>
<b>В.4.3 Талбай нь ойжуулалт хийх, мод тарих нөхцөл, орчин бүрдсэн эсэх</b>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тайлбар: <i>Талбайн байршил цэвдэгтэй эсэх, усалгаа хийх боломжтой эсэх.</i>
<b>В.4.4 Талбай нь тусгай хамгаалалттай газар нутаг эсвэл экологийн өндөр ач холбогдолтой бүсүүдэд хамаарах эсэх</b>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тайлбар: <i>Тусгай хамгаалалттай газар эсвэл экологийн өндөр ач холбогдолтой бүсэд төсөл хэрэгжүүлэх эсэх.</i>
<b>В.4.5 Талбай дахин төлөвлөлтийн бүсэд орсон эсэх</b>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тайлбар: <i>Төсөл хэрэгжүүлэх байршил дахин төлөвлөлтөд ороогүй байх.</i>
<b>В.4.6 Талбайтай холбоотой ямар нэг газрын маргаан байгаа эсэх</b>	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тайлбар: <i>Ашиглах, эзэмших, өмчлөх зөвшөөрөл авсан эсэх, газартай холбоотой ямар нэгэн маргаан байхгүй зэргийг баталгаажуулах.</i>
<b>В.4.7 Төслийн талбайд өмнө хийгдэж байсан ойжуулалт, ногоон байгууламжийн ажлын мэдээлэл</b>	<i>Өмнө ойжуулалт, ногоон байгууламжийн ажил хийгдэж байсан бол хэзээ, ямар санхүүжилтээр, ямар ажил хийгдэж байсан талаар товч бичих.</i>

**В.5 Төслийн явц.** Хэрэв төсөл хэрэгжиж эхэлсэн бол төслийн одоогийн явцын талаар товч тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

**В.6 Төслийн үр нөлөө.** Төслийг хэрэгжүүлснээр бий болох байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үр нөлөө, тэдгээрийг хэмжих шалгуур, баталгаажуулах аргачлалын талаар тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

**Төслийн үр дүн хэмжих шалгуур үзүүлэлтүүд**

Хэрэв зарим үзүүлэлт хамааралгүй эсвэл одоо тодорхойлох боломжгүй гэж үзвэл холбогдох үндэслэл, тайлбарыг оруулна уу.

Шалгуур үзүүлэлт	
Төслийн нийт талбайн хэмжээ (га)	
Төсөл хэрэгжүүлснээс өмнөх ногоон байгууламж бүхий талбайн нийт хэмжээ (га болон нийт талбайд эзлэх %)	
Төслийн хүрээнд байгуулахаар төлөвлөж буй ногоон байгууламжийн нийт хэмжээ (га болон нийт талбайн эзлэх %):	
Төслөөс үр шим хүртэх хүүхдийн тоо (хүйсээр ангилах)	
Төслөөс үр шим хүртэх багш, ажилтнуудын тоо (хүйсээр ангилах)	
Төслийн хүрээнд сургалтад хамруулах хүний тоо (хүйсээр ангилах)	
Бусад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үр нөлөө: <i>хүнсний хангамж аюулгүй байдал гэх мэт</i>	

**С. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө**

**С.1 Төслийн бүтэц зохион байгуулалт.** Төслийн ерөнхий бүтэц зохион байгуулалт, төслийн хэрэгжилт, хяналт, арчилгаа зэргийг хэрхэн удирдан зохион байгуулах, Сангаас сонгон шалгаруулах мод тарих ажлыг хариуцах мэргэжлийн байгууллагатай хэрхэн хамтран ажиллахаар төлөвлөж буй талаар тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

Төслийг хариуцах үндсэн багийн гишүүдийн мэдээллийг оруулах.

Овог нэр	Харья байгууллагын нэр, албан тушаал	Мэргэжил, ажилласан жил	Гүйцэтгэх үүрэг, хариуцлага	Нийт төсөлд зарцуулах хугацаа (сараар)	Хүйс

**С.2 Төсөл хэрэгжүүлэгчийн туршлага.** Төслийн үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын өмнө ижил төстэй төсөл хэрэгжүүлж байсан туршлага, хийгдсэн ажлууд болон үр дүнгийн талаар товч мэдээлэл оруулах.

Төслийн нэр	Он (эхэлсэн он – дууссан он)	Зорилго	Хийгдсэн ажил, үр дүн	Төслийн санхүүжүүлэгч/захиалагч	Хамтрагч байгууллагын мэдээлэл	Төслийн санхүүжилт дүн	Холбогдох линк, тайлан, хавсралт

Бусад туршлагын талаарх мэдээлэл, тайлбар:
--

**С.3 Хамтын ажиллагаа, оролцогч талууд.** Төслийн хүрээнд зорилтот бүлгүүдтэй хэрхэн уялдаж ажиллах, тэдгээрийн оролцоог хангах талаар хүснэгтийн дагуу тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

Зорилтот бүлэг	Үүрэг оролцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөө

**С.4 Хяналт, тайлагнал, мэдээлэл хуваалцах төлөвлөгөө.** Сангийн хяналт, тайлагналын шаардлагад нийцүүлэн төслийн үр дүнг хэрхэн хянах, судлах, хэмжих, тайлагнах, олон нийтэд мэдээлэл хуваалцах талаар тодорхой тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**С.5 Урт хугацааны арчилгаа, хамгаалалт.** Төслийн хүрээнд хийгдсэн ногоон байгууламжийг хэрхэн төслийн хугацаанд болон цаашид урт хугацаанд үр дүнтэйгээр арчилж авч явах талаар авах арга хэмжээ, төлөвлөгөөг тайбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

## D. Хамтын санхүүжилт

**D.1 Хамтын санхүүжилт.** Төслийн хүрээнд хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс гарах хамтын санхүүжилт болон бусад мөнгөн бус оролцоо байвал тодорхойлох.

Хамтын санхүүжилт олгох байгууллагын нэр	Хамтын санхүүжилтийн дүн	Хамтын санхүүжилтийн төсөлд эзлэх хувь	Хамтын санхүүжилтийн төрөл (төсөв, грант гэх мэт)	Хамтын санхүүжилтийг баталгаажуулах баримт бичиг байгаа эсэх (төсөв, дансны хуулга гэх мэт)
<b>Нийт</b>				

<b>Бусад мөнгөн бус оролцоо</b>	
---------------------------------	--

## E. Хавсралт, зөвшөөрөл, гарын үсэг

**E.1 Хавсралт.** Дараах хавсралтуудыг өргөдлийн хамт нэг pdf файл болгон илгээнэ үү.

- Хавсралт 1: Тохижилт хийх зай, талбайн одоогийн зураг, кадастрын зураг
- Хавсралт 2: Хэрэгжүүлэх төслийн төлөвлөгөөний зурган мэдээлэл, ландшафтын зураг (хэрэв байгаа тохиолдолд)
- Хавсралт 3: Төслийн багийн гишүүдийн товч намтар (CV)
- Хавсралт 4: Өмнө ижил төстэй төсөл хамтран хэрэгжүүлж байсан байгууллагын тодорхойлох захидал (2 ширхэг)

**E.2 Зөвшөөрөл.** Уг өргөдөл гаргах үйл ажиллагааны хүрээнд та дараах зөвшөөрлийг олгож байгааг баталгаажуулна үү.

Би энэхүү өргөдлийг явуулснаар өөрийн төслийн талаар мэдээлэл, тооцоог үнэн, зөв танилцуулсныг баталгаажуулж байна.	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
Би энэхүү өргөдлийг явуулснаар төсөл хэрэгжүүлэх талбайтай холбоотой ямар нэг маргаан асуудал байхгүй, холбогдох зөвшөөрөл, гэрчилгээ, лавлагааг гаргах боломжтойг баталгаажуулж байна.	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
Би энэхүү өргөдлийг явуулснаар уг төслийн талаар мэдээлэл, тооцоог Сангийн ажилтан, удирдлага, техникийн хорооны гишүүд, зөвлөхүүдтэй хуваалцахыг зөвшөөрч байна.	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
Би энэхүү өргөдлийг явуулснаар Сангаас ямар нэг санхүүжилтийн шууд үүрэг хүлээхгүй болохыг ойлгож, хүлээн зөвшөөрч байна.	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

**E.3 Гарын үсэг.** Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын гарын үсгийг оруулна үү.

Овог нэр:

Албан тушаал:

Он, сар, өдөр:

---

Гарын үсэг, тамга

## Төслийн санал ирүүлэх маягт

### Чиглэл 2 - Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

Санхүүжүүлэгч: Тэрбум мод сан

Төслийн санал хүлээн авах сүүлийн хугацаа: 2024 оны 12-р сарын 16-ны өдрийн 17:00 цаг хүртэл

Нэг төсөлд олгох дээд хэмжээ: 100'000'000 сая төгрөг хүртэл

Төслийн хэрэгжиж эхлэх хугацаа: 2025 оны II улирал

Төсөл хэрэгжүүлэх байршил: Монгол Улсын нутаг дэвсгэр

#### Төслийн ерөнхий агуулга, зорилго

Энэхүү төслийн хүрээнд ойн хомсдол доройтлыг бууруулах, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор түймэр, хөнөөлт шавж, хууль бус мод бэлтгэлийн үлмаас доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, байгалийн сэргээн ургалтанд туслах, мод тарихтай холбоотой төсөл хөтөлбөр багтана.

#### Төслийн хамрах хүрээ

Энэхүү чиглэлд Монгол Улсаас өргөдөл гаргаж буй иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн байгууллага, ойн нөхөрлөл, судалгааны байгууллага болон бусад холбогдох байгууллага хамаарна.

Хувь хүн, ашгийн төлөө болон худалдаа арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагууд хөтөлбөрт хамрагдах боломжгүй боловч дээрх байгууллагуудтай хамтарсан төслийн санал ирүүлэх боломжтой.

Өргөдөл гаргагч нь нэгээс дээш хөтөлбөрийн санал ирүүлж болно. Төслийг хоёр ба түүнээс дээш байгууллага хамтран боловсруулж, өргөдөл гаргах боломжтой.

Төслийн санал ирүүлэхийн өмнө “Төсөл сонгон шалгаруулах тухай удирдамж”-тай сайтар танилцсаны дараагаар дараах маягтыг бөглөнө үү. Төслийн маягтыг бөглөхдөө асуултанд бүрэн гүйцэт, ойлгомжтой хариулсан эсэх, материалаа гүйцэт ирүүлсэн зэргийг сайтар нягталж ирүүлнэ үү. Төслийн материал ирүүлэхтэй холбоотой асуух зүйл байвал [info@billiontree.mn](mailto:info@billiontree.mn) хаягаар ирүүлэх боломжтой.

Бүрэн гүйцэт бөглөсөн өргөдлийг холбогдох хавсралтын хамт **2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 17:00 цагаас** өмнө [info@billiontree.mn](mailto:info@billiontree.mn) хаягаар бүртгэл үүсгэн илгээнэ үү.

#### Өргөдлийг явуулахдаа

- Хариулт бүрийг заасан үгийн тоо, нүүрний хязгаарлалтад багтааж, нийт төслийн санал, өргөдлийг **20 хуудаст** багтаана үү. Үүнд хавсралтууд хамаарахгүй.
- Өргөдлийг хавсралтын хамт бүрэн гүйцэт бөглөнө үү. **Дутуу бөглөсөн өргөдлийг хүлээн авахгүйг** анхаарна үү.
- Өргөдлийг **pdf хэлбэрээр** бэлтгэж, файлын “2025 C2 – *Байгууллагын нэр*” загвараар хадгална үү.

## А. Төслийн ерөнхий мэдээлэл

### А.1 Төслийн ерөнхий мэдээлэл

А.1.1 Төслийн нэр	
-------------------	--

<b>А.1.2 Төслийн хамаарах чиглэл (сонгох)</b>	Чиглэл 2 – Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих үйл ажиллагааг өргөжүүлэх төсөл		
<b>А.1.3 Төслийн төрөл</b>	<input type="checkbox"/> Ойжуулалт <input type="checkbox"/> Нөхөн сэргээлт <input type="checkbox"/> Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж <input type="checkbox"/> Бусад		
<b>А.1.4 Төслийн байршил, албан ёсны хаяг</b>		<b>төгрөг</b>	<b>%</b>
	Сангаас хүсч буй санхүүжилтийн дүн (боломжит дээд хэмжээ 100 сая төгрөг)		
	Хамтын санхүүжилт (хамгийн багадаа 20 хувийг бүрдүүлэх)		
<b>Нийт төслийн төсөв</b>			
<b>А.1.5 Төслийн нийт төсөв</b>			
<b>А.1.6 Төслийн хэрэгжих хугацаа</b>	<b>Эхлэх он/сар/өдөр</b>	<b>Дуусах он/сар/өдөр</b>	<b>Нийт төслийн хугацаа (сараар)</b>
<b>А.1.7 Төслийн товч танилцуулга</b> (100 үгэнд багтаах)			

### А.2 Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл

<b>А.2.1 Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын нэр</b>		<b>А.2.2 Хуулийн этгээдийн хэлбэр</b>	
<b>А.2.3 Регистерийн дугаар</b>		<b>А.2.4 Байгуулагдсан огноо</b>	
<b>А.2.5 Үйл ажиллагааны чиглэл</b>		<b>А.2.6 Ажилтны тоо (бүтэн цагийн)</b>	Эрэгтэй: Эмэгтэй:
<b>А.2.7 Байгууллагын ерөнхий үйл ажиллагааны талаар товч мэдээлэл</b>			
<b>А.2.8 Тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт</b>	<b>Тусгай зөвшөөрлийн нэр</b>	<b>Авсан он</b>	<b>Олгосон байгууллага</b>
<b>А.2.9 Байгууллагын бусад мэдээлэл</b>	Цахим шуудан: Утасны дугаар: Албан ёсны хаяг: Цахим хуудас: Сошиал хаягууд:		
<b>А.2.10 Удирдлагын мэдээлэл</b>	Овог нэр: Албан тушаал: Цахим шуудан: Утасны дугаар:		
<b>А.2.11 Хариуцсан ажилтны мэдээлэл</b>	Овог нэр: Албан тушаал: Цахим шуудан: Утасны дугаар:		

### А.3 Хамтран хэрэгжүүлэгч, дэмжигч байгууллагын талаар мэдээлэл

<b>А.3.1 Хамтран хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл</b>	<b>Байгууллагын нэр</b>	<b>Байгууллагын төрөл</b>	<b>Хариуцсан ажилтны нэр, албан тушаал</b>	<b>Холбоо барих имэйл хаяг, утасны дугаар</b>
<b>А.3.2 Холбогдох, дэмжигч байгууллагын мэдээлэл</b>	<b>Байгууллагын нэр</b>	<b>Байгууллагын төрөл</b>	<b>Хариуцсан ажилтны нэр, албан тушаал</b>	<b>Холбоо барих имэйл хаяг, утасны дугаар</b>



## В. Төслийн дэлгэрэнгүй мэдээлэл

**В.1 Төслийн одоогийн нөхцөл байдал.** Төслийн нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үндэслэлийг тайлбарлах. Төслийг өөр бусад санхүүгийн механизм (зээл, төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалт гэх мэт)-ээр яагаад санхүүжүүлэх боломжгүй талаар тодруулах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**В.2 Төслийн зорилго, үр дүн.** Төслийн ерөнхий зорилго, хүрэх үр дүн, тэдгээр нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөний стратеги, Сангийн зорилго, болон бусад үндэсний болон олон улсын холбогдох бодлого, зорилтуудтай хэрхэн нийцэж буйг тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**В.3 Төслийн аргачлал.** Төслийн хүрээнд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээг тайлбарлах. Үүнд газар/хөрс бэлтгэх, тарьц тарих, ойжуулалт хийх, арчлах, хянахтай холбоотой бүхий л ажлыг багтаана. Мөн тарих мод, үр, тарьцын төрөл, нас, тоо, тарилтын схем, арга, хашаа, хайс зэрэг хамгаалалт хийх шаардлага байгаа эсэх, эдгээрийг тухайн газрын байгалийн онцлогт нийцүүлсэн эсэх, холбогдох үнэлгээ, судалгаа, ландшафтын зураг, төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулах, хавсаргах (1 нүүрнээс илүүгүй).

--

**Төслийн төлөвлөгөө.** Төслийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын календарчилсан төлөвлөгөөг оруулах.

No.	Арга хэмжээний төрөл	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний тайлбар	Үр дүн	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
<b>Үйл ажиллагаа 1:</b>					
<b>Үйл ажиллагаа 2:</b>					
<b>Үйл ажиллагаа 3:</b>					
<b>Үйл ажиллагаа 4:</b>					
<b>Үйл ажиллагаа 5:</b>					
Нэмэлт тайлбар:					

**Талбайн төлөвлөгөө.** Төслийн хүрээнд тарих мод, тарьцын төлөвлөгөө, талбайн мэдээллийг оруулах.

No.	Талбайн нэр	Талбайн байршил	Тарилт хийх он	Тарьц, суулгацын тоо	Тарих/нөхөн сэргээх талбайн хэмжээ (га)	Тарьц, суулгацын төрөл	Тарьц, суулгацын нас/хэмжээ	Тарьц, суулгацын нэгж үнэ



**В.6 Төслийн тогтвортой, шинэлэг байдал.** Төсөл нь олон улсын сайн туршлага, тогтвортой ойн менежментийн стандарт бусад дэвшилтэт техник, технологийг ашигласан эсэх талаар тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**В.7 Төслийн явц.** Хэрэв төсөл хэрэгжиж эхэлсэн бол төслийн одоогийн явцын талаар товч тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**В.8 Төслийн үр нөлөө.** Төслийг хэрэгжүүлснээр бий болох байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үр нөлөө, тэдгээрийг хэмжих шалгуур, баталгаажуулах аргачлалын талаар тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**Төслийн үр дүн хэмжих шалгуур үзүүлэлтүүд**

Хэрэв зарим үзүүлэлт хамааралгүй эсвэл одоо тодорхойлох боломжгүй гэж үзвэл холбогдох үндэслэл, тайлбарыг оруулна уу.

Шалгуур үзүүлэлт	Суурь нөхцөл	Зорилтот түвшин (2023)	Зорилтот түвшин (2024)	Зорилтот түвшин (2025)	Зорилтот түвшин (нийт төслийн хугацаанд)	Хэмжих, баталгаажуулах аргачлал
<b>Байгаль орчны үр нөлөө</b>						
Нийт ойжуулалт хийх талбайн хэмжээ (га)						
Нийт нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ (га)						
Нийт цэцэрлэгжүүлэлт хийх талбайн хэмжээ (га)						
Нийт тарих мод/тарьцын тоо						
Зорилтот амьдралтын хувь (%)						
Хүлэмжийн хийн шингээлт (тонн CO2-экв)						
Шинээр туршсан техник, технологи, шийдлийн тоо						
Бусад: <i>эко системийн зэрэг нөлөө, уур амьсгалын өөрчлөлт, гэх мэт</i>						
<b>Нийгмийн үр нөлөө</b>						
Төслөөс үр шим хүртэх нийт хүн амын тоо (хүйсээр ангилах)						
Төслийн хүрээнд сургалтад хамруулах хүний тоо (хүйсээр ангилах)						
Шинээр бий болох ажлын байрны тоо (эр/эм)						
Төслийн хүрээнд бий болох орлого (төгрөгөөр)						
Бусад: <i>жендэрийн үр нөлөө, нутгийн иргэдийн оролцоо, хүнсний хангамж аюулгүй байдал гэх мэт</i>						
Нэмэлт тайлбар, үндэслэл, ашигласан тооцох аргачлалын талаарх мэдээлэл:						

**С. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө**

**С.1 Төслийн бүтэц зохион байгуулалт.** Төслийн ерөнхий бүтэц зохион байгуулалт, тарьц, суулгац, үр, бусад материалын сонголт, төслийн хэрэгжилт, арчилгаа зэргийг хэрхэн удирдан зохион байгуулах, оролцож байгаа

хүмүүс бүгд тухайн чиглэлээр мэргэшсэн эсэх, үгүй бол мэргэжлийн чиглэл өгч ажиллуулах эсэх талаар тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

Төслийг хариуцах үндсэн багийн гишүүдийн мэдээллийг оруулах.

Овог нэр	Харъя байгууллагын нэр, албан тушаал	Мэргэжил, ажилласан жил	Гүйцэтгэх үүрэг, хариуцлага	Нийт төсөлд зарцуулах хугацаа (сараар)	Хүйс

**С.2 Төсөл хэрэгжүүлэгчийн туршлага.** Төслийн үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын өмнө ижил төстэй төсөл хэрэгжүүлж байсан туршлага, хийгдсэн ажлууд болон үр дүнгийн талаар товч мэдээлэл оруулах.

<b>Төсөл хэрэгжүүлэгчийн нийт ажилласан жилийн туршлага</b>	
<b>Төсөл хэрэгжүүлэгчийн нийт тарьсан модны тоо</b>	

Төслийн нэр	Он (эхэлсэн он – дууссан он)	Зорилго	Хийгдсэн ажил, үр дүн	Төслийн санхүүжүүлэгч/захиалагч	Хамтрагч байгууллагын мэдээлэл	Төслийн санхүүжилт дүн	Холбогдох линк, тайлан, хавсралт

<b>Бусад туршлагын талаарх мэдээлэл, тайлбар:</b>

**С.3 Хамтын ажиллагаа, оролцогч талууд.** Төслийн хүрээнд зорилтот бүлгүүдтэй хэрхэн уялдаж ажиллах, тэдгээрийн оролцоог хангах талаар хүснэгтийн дагуу тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

Зорилтот бүлэг	Үүрэг оролцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөө	Хамтын ажиллагаа баталгаажсэн эсэх/баталгаажуулах төлөвлөгөө

**С.4 Хяналт, тайлагнал, мэдээлэл хуваалцах төлөвлөгөө.** Сангийн хяналт, тайлагналын шаардлагад нийцүүлэн төслийн үр дүнг хэрхэн хянах, судлах, хэмжих, тайлагнах, олон нийтэд мэдээлэл хуваалцах талаар тодорхой тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**С.5 Урт хугацааны арчилгаа, хамгаалалт.** Төслийн хүрээнд хийгдсэн ойжуулалт, ногоон байгууламжийг хэрхэн төслийн хугацаанд болон цаашид урт хугацаанд үр дүнтэйгээр арчилж авч явах талаар авах арга хэмжээ, төлөвлөгөөг тайлбарлах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**С.6. Эрсдэлийн удирдлага.** Төслийг хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй хүндрэл, бэрхшээл, эрсдэлүүд (инфляци, КОВИД-19 гэх мэт)-ийг тодорхойлох. Түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, даван туулах, мөн нөлөөллийг бууруулах талаар бичих (0.5 нүүрнээс илүүгүй).

Үүсч болзошгүй эрсдэл/бэрхшээл	Эрсдэл бууруулах төлөвлөгөө

## D. Төсөв, хамтын санхүүжилт

**D.1 Төслийн төсөв.** Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах бүхий л зардлыг нарийвчлан задалж, тусгасан төсвийг оруулах. Удирдамжинд дурдсан санхүүжүүлэх болон санхүүжүүлэхгүй үйл ажиллагааг сайтар уншиж түүнтэй нийцтэй байгаа эсэхийг нягтлах.

No	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төг) төг	Нийт дүн (төг) төг	Сангаас хүсч буй дүн		Хамтын санхүүжилт-ийн дүн	
						төг	%	төг	%
1.	Цалин, хөлс								
2.	Гэрээт, зөвлөх үйлчилгээ								
3.	Үр, тарьц суулгац, мод								
4.	Хашаа, тохижилт								
5.	Газартай холбоотой зардал								
6.	Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бусад материал хангамж								
7.	Сургалт, судалгаа								
8.	Уулзалт, арга хэмжээ								
9.	Тээвэр, дотоодын аялал								
10.	Орчуулга, хэвлэлт, мэдээлэл								
11.	Бусад...								
12.	Болзошгүй зардал								
<b>Нийт дүн</b>									
<b>Нийт дүн (1 дэх жилд)</b>									
<b>Нийт дүн (2 дахь жилд)</b>									
<b>Нийт дүн (3 дахь жилд)</b>									
<b>Төслийн хүрээнд тарих 1 модны өртөг (Төслийн нийт дүн/тарих модны тоо)</b>									

**Төсвийн үндэслэл, тооцоо.** Төсөлд зарцуулагдах төсвийн тооцоолол, үндэслэл, үнийн харьцуулалт, зах зээлийн үнэд хэрхэн нийцсэн талаар тайлбарлах. Өргөдлүүдийг үнэлэхдээ төсөв, нийт тарих модны тоо, нас, төрөл, талбайн хэмжээ, үр дүн зэргийг харгалзаж, харьцуулалт хийнэ (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**D.2 Санхүүгийн чадавхи.** Сангаас тавих санхүүгийн тайлагнал, аудитын шаардлагыг хангаж ажиллах боломжтойг баталгаажуулсан мэдээлэл, байгууллагын хүний нөөц, туршлагын талаар мэдээлэл оруулах (0.5 нүүрнээс илүүгүй).

--

**D.3 Хамтын санхүүжилт.** Төслийн хүрээнд хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс гарах хамтын санхүүжилт болон бусад мөнгөн бус оролцоог тодорхойлох.

Хамтын санхүүжилт олгох байгууллагын нэр	Хамтын санхүүжилтийн дүн	Хамтын санхүүжилтийн төсөлд эзлэх хувь	Хамтын санхүүжилтийн төрөл (зээл, грант, хөрөнгө оруулалт гэх мэт)	Хамтын санхүүжилтийг баталгаажуулах баримт бичиг байгаа эсэх (захидал, тодорхойлолт, дансны хуулга гэх мэт)
<b>Нийт</b>		ювд		

<b>Бусад мөнгөн бус оролцоо</b>	
---------------------------------	--

## Е. Хавсралт, зөвшөөрөл, гарын үсэг

**Е.1 Хавсралт.** Дараах хавсралтуудыг өргөдлийн хамт нэг pdf файл болгон илгээнэ үү.

- Хавсралт 1: Тохижилт хийх зай, талбайн одоогийн зураг, кадастрын зураг
- Хавсралт 2: Хэрэгжүүлэх төслийн төлөвлөгөөний зурган мэдээлэл, ландшафтын зураг
- Хавсралт 3: Төслийн багийн гишүүдийн товч намтар (CV)
- Хавсралт 4: Өмнө ижил төстэй төсөл хамтран хэрэгжүүлж байсан байгууллагын тодорхойлох захидал (2 ширхэг)
- Хавсралт 5: Өмнөх оны санхүүгийн тайлангийн хуулбар
- Хавсралт 6: Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Хавсралт 7: Бусад (тусгай зөвшөөрлийн хуулбар гэх мэт)

**Е.2 Зөвшөөрөл.** Уг өргөдөл гаргах үйл ажиллагааны хүрээнд та дараах зөвшөөрлийг олгож байгааг баталгаажуулна үү.

Би энэхүү өргөдлийг явуулснаар өөрийн төслийн талаар мэдээлэл, тооцоог үнэн, зөв танилцуулсныг баталгаажуулж байна.	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
Би энэхүү өргөдлийг явуулснаар төсөл хэрэгжүүлэх талбайтай холбоотой ямар нэг маргаан асуудал байхгүй, холбогдох зөвшөөрөл, гэрчилгээ, лавлагааг гаргах боломжтойг баталгаажуулж байна.	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
Би энэхүү өргөдлийг явуулснаар уг төслийн талаар мэдээлэл, тооцоог Сангийн ажилтан, удирдлага, техникийн хорооны гишүүд, зөвлөхүүдтэй хуваалцахыг зөвшөөрч байна.	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
Би энэхүү өргөдлийг явуулснаар Сангаас ямар нэг санхүүжилтийн шууд үүрэг хүлээхгүй болохыг ойлгож, хүлээн зөвшөөрч байна.	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

**Е.3 Гарын үсэг.** Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын гарын үсгийг оруулна үү.

Овог нэр:

Албан тушаал:

Он, сар, өдөр:

---

Гарын үсэг, тамга